



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/96

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дүгээр зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Монголын тусгай олимпийн хороотой хамтран зохион байгуулж буй “Боломжийг бүгдэд” төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй говийн бүсийн уулзалт сургалтад оролцох оюуны бэрхшээлтэй хүүхдүүд болон асран хамгаалагч, багш, төрийн албан хаагчдын замын зардалд 2,805,300 (хоёр сая найман зуун таван мянга гурван зуун) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Холбогдох зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

